



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.03.05 № 24-112-12/496  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Ширмэн хаалтууд” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим (tender.gov.mn) системээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ЗАХИРГАА, УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН  
ГАЗРЫН ДАРГА



Д.ҮҮРИЙНТУЯА

612407004589

## ТОДРУУЛГА

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хэрэгцээт “Ширмэн хаалтууд” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерг оролцохыг сонирхогчдоос дараах тодруулга гарсан байна.

### Үүнд:

Ижил төстэй ажлын мэдээлэл, Санхүүгийн чадавхийн мэдээлэл 2021,2022 оныг шаардсан байна. 2023 оны мэдээлэл явуулах шаардлагатай юу. Тодруулга өгнө үү.

### Тодруулгын хариу:

Захиалагчийн тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн

“ТШЗ 18.1.2 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл Ижил төстэй бараа нийлүүлж байсан туршлагыг дараах байдлаар нотолно. Үүнд:

1. 2021, 2022 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлж байсныг ойлгоно.
2. Ижил төстэй гэдэгт "Төрөл бүрийн ган бэлдэц" нийлүүлж байсныг ойлгоно.
3. Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. (Хэрэв "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардахгүй)

4. Оролцогч нь V бүлгийн Маягт 3 "Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл", Маягт 5 "Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл"-ийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.

~~ТШЗ 18.1.4~~ Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага 1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022 оны аль нэг жилд санал болгож байгаа үнийн дүн 100 хувиас багагүй байна. 2. Тендерг оролцогч нь 2021, 2022 он тус бүр ашигтай ажилласан байна” гэж тус тус заасан байх тул батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичигт шаардсан материалыг ирүүлнэ үү.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

  
Т.АТАРБАЯР

  
Ч.ОТГОНБААТАР

2024.03.04